

СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.05.11. №52 (521)

ҮЙЛ ЯВДАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗХЖШ-ЫН ДАРГЫГ ОХУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН ТУШААЛААР ШАГНАЛАА



ОХУ-ын Батлан хамгаалахын сайдын тушаалаар Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзоригийг “Цэргийн хамтын ажиллагааг бэхжүүлэхийн төлөө” медалиар шагнасныг ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны цэрэг, агаарын атташе, хурандаа П.Г.Анисов өчигдөр гардуулан өглөө. Хурандаа П.Г.Анисов “Аугаа их Эх орны дайны ялалтын 76 жилийн ойг тохиолдуулан ОХУ-ын Батлан хамгаалахын сайд Сергей Шойгугийн тушаалаар хоёр улсын цэргийн хамтын ажиллагааг өргөжүүлж, бэхжүүлэхэд оруулж буй хувь нэмрийг тань үнэлж энэхүү хүндтэй медалиа ирүүлснийг танд гардуулан өгч байгаадаа баяртай байна. ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад улсын Улаан-Үд хотод зохион байгуулагдсан Аугаа их Эх орны дайны ялалтын 76 жилийн ойн цэргийн ёслолын жагсаалд Монгол Улсын Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнийг илгээн оролцуулсанд баярлалаа” гээд хоёр улсын Зэвсэгт хүчний харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Тухайлбал, “Олон улсын цэргийн наадам”-ын төрлүүд болох “Аравт-2021”, “Цэргийн авто ралли-2021” уралдааныг энэ жил Монгол Улсын Зэвсэгт хүчин зохион байгуулахтай холбоотойгоор санал солилцож, зарим чиглэлүүдэд тодотгосон юм. Уулзалтад Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Г.Одбаяр байлцсан юм.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙХЭЭ ТҮҮХЭН ОЙГООР ЗАРИМ АЛБА ХААГЧИД ЭНГЭРЭЭ МЯЛААВ



Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын зарим алба хаагч Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн одон, медаль хүртлээ. Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор тускомандлалын Агаарын довтолгооноос хамгаалах хэлтсийн дарга, хурандаа Э.Батсайхан, Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн Бэлэн байдал, дайчилгааны офицер, дэд хурандаа К.Амгаланжамц, Цэргийн гавьяаны одонгоор Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн төлөвлөлтийн ахлах офицер, хурандаа Ж.Одсүрэн, Байлдааны жижүүрлэлтийн албаны Төв командын байрын дарга, хурандаа Д.Батмөнх, Цэргийн хүндэт медалиар Агаарын довтолгооноос хамгаалах хэлтсийн Зенит пуужингийн ахлах офицер-ерөнхий инженер, хурандаа Т.Энхбат шагнагдав. Мөн ОБЕГ-аас

“Албаны төлөө-1” хүндэт медалиа Улсын нисэхийн хэлтсийн дарга, хурандаа Н.Очирбатат “Гамшиг ослын үед бидэнд дэмжлэг үзүүлж, ард түмний амь нас, эд хөрөнгө, байгаль орчныг авран хамгаалах үйлсэд оруулж буй хувь нэмэрт тань баярлалаа” хэмээн ирүүлснийг Агаарын цэргийн командлагч, хошууч генерал О.Энхбаяр өчигдөр гардуулан өгч, баяр хүргэлээ.

ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 7	☁️ -4
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	☁️ 22
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 25	☁️ 21

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,845.00	2,856.00
EUR 🇪🇺	3,437.00	3,497.00
CNY 🇨🇳	443.00	446.60
RUB 🇷🇺	38.10	39.80
JPY 🇯🇵	25.91	26.41
KRW 🇰🇷	2.47	2.61

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 30
2021.05.11.
/МЯГМАР ГАРАГ/
**ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ
САРЫН ГУРВАН ХӨХ
ШАРАГЧИН ХОНЬ ӨДӨР**

Үс засуулбал:
Эрлэг лугаа учирна.
Наран ургах, шингэх:
05.19-20.18
Барилдлага:
Арвидах
Шүтэн барилдлага:
Мунхрахуй
Суудал:
Отгоргуй.

Арлын тооллын 5 дугаар сарын 11, Ангарга гараг. Билгийн тооллын 30, Гоё хүүхэн одтой, шарагчин хонь өдөр. Өдрийн наран 5 цаг 19 минутад мандан, 20 цаг 18 минутад жаргана. Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагд хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, хүү сангийн эх татах, эд агуурс авах, зээл авах арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, лус тахих, мал худалдан авах, мал түгээх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Цөөрөм байгуулах, сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогосод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



ТӨРИЙН ОДОН, МЕДАЛЬ ХҮРТСЭН ЗАРИМ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ШАГНАЛЫГ ГАРДУУЛЛАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан эх орноо батлан хамгаалах үйлсэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж, Зэвсэгт хүчний зарим бүрэлдэхүүнийг Монгол Улсын төрийн одон, медалиар шагнасан билээ. Түүхт ойг тохиолдуулан эрхэлсэн албандаа үр бүтээлтэй ажиллаж байгаа бүрэлдэхүүнд олгогдсон төрийн одон, медаль, салбарын шагналыг ЗХЖШ-ын Хүний нөөцийн хэлтсээс Төрлийн цэргийн командлалууд, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад хүргүүлээд байна.

Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг өчигдөр Ерөнхийлөгчийн зарлигаар Төрийн одон, медаль хүртсэн ЗХЖШ-ын зарим бүрэлдэхүүний шагналыг гардуулан өгч, баяр хүргэв.

Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ц.Жавхланбаатар, Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн командлагч, бригадын генерал Д.Баасандамба, ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч

Б.Гантөмөр, Санхүүгийн хэлтсийн дарга, хурандаа Б.Бүрэнтөгс, Хүний нөөцийн хэлтсийн дарга, хурандаа Н.Гантөмөр, Захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа Ц.Батмөнх нар шагнагдлаа.

Мөн Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, хошууч генерал О.Энхбаяр, Цэргийн гавьяаны одонгоор Бодлого, стратеги төлөвлөлтийн газрын орлогч, хэлтсийн дарга, хурандаа Ш.Амарбаясгалан, Материал, техникийн газрын Хэмжил зүйн албаны дарга, хурандаа Ч.Бат-Эрдэнэ, “Алтан гадас” одонгоор Захиргааны удирдлагын хэлтсийн хэвлэгч, операторч П.Батжаргал, Батлан хамгаалахын сайдын тушаалаар “Дайчин алдар II” медалиар Цэргийн албаны хэлтсийн дарга, хурандаа Д.Адъяабазар нар шагнагдсаныг гардуулан өгсөн юм. Хошууч генерал Д.Ганзориг Зэвсэгт хүчний түүхэн жилээр төрийн одон, медаль хүртсэнд баяр хүргээд, илүү хичээл чармайлттай, бүтээлч ажиллахыг тус бүрэлдэхүүнд захилаа.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
45.459	32.660	170/12
ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ		
НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
2187 (28)	273	1883

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД
Тохиолдол Нийт: 157,289,118
Эдгэрсэн Нийт: 130,729,059
Нас барсан Нийт: 3,277,272

ТАНДАЛТ	
ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 38,599 2,213,376
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /ПГУ/ СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 5,250 2,785,411
ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 1,731 393,705
ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ХҮН СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 418 72,716

ЦАХИМ ШУУДАНД

“МОНГОЛ АРД” ЭСКАДРИЛИЙН ТҮҮХЭЭР ИЛТГЭЛ ТАВИВ

1941-1945 оны Аугаа их Эх орны дайны ялалтын 76 жилийн ойг тохиолдуулан Бүх Оросын Цэрэг-эх оронч “Юнармия” хөдөлгөөний Буриадын салбарын санаачилгаар Монгол Улсын Ахмад дайчдын “Улаан одхон” сонины зөвлөл “Дэлхийн хоёрдугаар дайн, түүний сургамж” сэдэвт Эрдэм шинжилгээний цахим бага хурлыг 2021 оны 5 дугаар сарын 8-ны өдөр зохион байгууллаа.



Бага хурлыг Батлан хамгаалахын Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, доктор, профессор, хурандаа Б.Мөнхсайхан, ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улсын Засгийн газрын Шадар сайд В.Б.Цыбикжапов нар нээж, хүн төрөлхтнийг фашизмын боолчлолоос аварсан Эх орны дайны ялалт өнөөдөр ч ирээдүй, хойч үеийнхэнд сургамжтай, эх орноо хайрлах үзэл санааг түүчээлэх ач холбогдолтой үйл явдал хэвээр байгааг онцлон тэмдэглэв.

Батлан хамгаалахын Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор, хошууч Т.Сүхбаатар “Монгол Ардын Хувьсгалт цэрэг Манжуурын стратегийн давшин операцид”, ОХУ-ын Улаан Үд дэх боловсролын төвийн ажилтан, түүхийн ухааны доктор Д.Л.Доржиев Эх орны дайны фронтуудад Монгол дайчид хэрхэн тулалдсан тухай, доктор, дэд профессор Лха.Баяр “Монголын ард түмнээс Зөвлөлтийн Улаан армид үзүүлсэн тусламж”, Бүх Оросын Цэрэг-эх оронч “Юнармия” хөдөлгөөний Буриадын салбарын штабын дарга, дэд хурандаа В.В.Ефремов дайнд амь үрэгдсэн цэргүүдийг нэхэн тодруулах, дурсгалыг нь мөнхжүүлэх талаар хийгдэж ажлын талаар сонирхолтой илтгэл тавьж хэлэлцүүлсэн.

Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсийн ерөнхий инженер, ахмад Э.Мөнх-Эрдэнэ “Монгол ард” нисэх эскадрилийн дайчин замналын түүхээр илтгэл тавьж сонордуулав. Тэрээр дайны жилүүдэд гвардын ахмад Н.П.Пушкин, ахлах дэслэгч Н.Я.Зеньковичийн удирдлагаар тус эскадрилийн нисгэгчид нийт 8474 байлдааны нислэг, 399 агаарын тулаан хийж, дайсны 327 онгоц, олон тооны амьд хүч, техникийг устгасан. “Монгол ард” эскадрилийн бүрэлдэхүүнд ЗХУ-ын баатар А.Н.Пушкин, А.И.Майоров, М.Е.Рябцев нар тулалдаж байсан талаар дурдсан юм.

Ахмад Э.Мөнх-Эрдэнэ тавьсан илтгэлдээ “Монгол ард” нисэх эскадриль нь дайны дараах жилүүдэд Герман, Унгар, Чехословак, Азербайжан, Украин, Монгол зэрэг улсуудад шилжин байрлаж, 1945-2014 оны хооронд олон удаа бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөд орсон. Энэ хугацаанд тус нисэх

эскадрилийн бүрэлдэхүүн Ла-7, Ла-9, МиГ-15, МиГ-17, МиГ-21ПФ, МиГ-21ПФМ, МиГ-21БИС, МиГ-23БМ (МиГ-27), Су-25 зэрэг онгоцнуудыг чадварлагаар эзэмшжээ. Монгол Улсад 1968-1990 онуудад “Монгол ард” хэмээх улаан бичигтэй МиГ-17, МиГ-21, МиГ-27К онгоцнуудаар нисэж байсан зэрэг олон сонирхолтой баримтыг хөндлөө.

Цахим бага хурлын завсарлагаанаар “Дэлхийн хоёрдугаар дайн”, “1945 оны Чөлөөлөх дайн”-ы сэдвээр бүтээсэн хоёр шинэ клипийг үзүүлсэн нь судлаачид, оролцогчдын сонирхлыг татлаа. Ийнхүү 1941-1945 оны Эх орны дайны ялалтын 76 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан Эрдэм шинжилгээний хурал цэрэг-дайны түүхийн баримтыг судалгааны эргэлтэд оруулж, нийтийн хүртээл болгох, эрдэмтэн судлаачид тухайн сэдвээр өөр өөрсдийн санал бодлыг солилцсон үр өгөөжтэй арга хэмжээ болов.


Хурандаа Г.НЯМДОРЖ

ЦАХИМ СУРГАЛТУУД ЯВАГДСААР БАЙНА

Батлан хамгаалах боловсролыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Багшийн хөгжил, заах арга зүйн” чиглэлээр цахим сургалт үе шаттайгаар зохион байгуулагдсаар байна. Тухайлбал, олон улсын сургагч багш нартай хамтран зохион байгуулагдсан ээлжит “Big Blue Button-BBB” сургалтад БХУ-ийн багш, хошууч Г.Золжаргал, АБС-ийн багш М.Индрабүд нар амжилттай оролцлоо. Мөн НАТО-ийн e-Academy-ийн олон улсын сургагч багш нартай хамтран “Н5Р

Micro-learning” буюу ахисан төвшний шинэ сургалтыг энэ сарын 06-19-ний өдрүүдэд зохион байгуулж байна. Тус сургалтад ҮБХИС-ийн 8 багш оролцож байгаа бөгөөд тухайн сургалтад хамрагдсанаар цахим сургалтын төлөвлөгөө, агуулга боловсруулах аргачлалаас суралцаж байна. Түүнчлэн Interactive presentation болон video content, цахим шалгалтын материал боловсруулж сурах зэрэг чадваруудыг давхар эзэмшиж төгсөх юм.


ОЮУТНЫ ИЛТГЭХ УРЛАГИЙН ТЭМЦЭЭН АНХ УДАА ОНЛАЙНААР ЗОХИОГДОЖ БАЙНА



Даян дэлхийн цар тахалтай холбогдуулан энэ сарын 8-ны өдөр ҮБХИС-ийн илтгэх урлагийн аварга шалгаруулах “Хөгжлийн гарц” тэмцээний анх удаа онлайн хэлбэрээр зохион байгуулав. Тэмцээний тус их сургуулийн Сонсогч сурагч оюутны холбоо, “Давах цаг” илтгэх урлаг мэтгэлцээний клуб хамтран зохион байгуулж байгаа юм. “Хөгжлийн гарц” нэгдсэн сэдвийн дор “Нийгмийн үнэт зүйл”, “Хувь хүний хөгжил”, “Миний сургууль” сэдвүүдээр оюун ухаан, эрдэм мэдлэгээр өрсөлдөх юм. Ташрамд сонирхуулахад, “Давах цаг” илтгэх урлаг, мэтгэлцээний клуб нь ҮБХИС-ийн хэмжээнд сонсогч, оюутнуудын илтгэх, мэтгэлцэх болон бусад хувь хүний хөгжлийг дэмжих зорилготой үйл

ажиллагааг Сонсогч Сурагч Оюутны Холбоотой хамтран зохион байгуулдаг юм. 2017 оноос өнөөдрийг хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулсаар байгаа энэ клуб улсын хэмжээнд их, дээд сургуулиудын мэтгэлцээний клубуудын чансаа тогтоох Монгол Улсын шадар сайдын ивээл дор зохион байгуулагдсан “Парламентын мэтгэлцээний үндэсний аварга шалгаруулах” XI тэмцээнд оролцож V байранд эрэмбэлэгджээ. Өнгөрсөн хугацаанд ҮБХИС-ийн мэтгэлцээний аварга шалгаруулах анхдугаар тэмцээнийг зохион байгуулснаас гадна клубийн болон уралдаануудад оролцох сонсогч, оюутнуудаа дотооддоо сургалт зохион байгуулж чадваржуулсаар байгаа юм байна.

ЗАХИРАГЧТАЙГАА ХАМТ



Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

Аугаа их эх орны дайны ялалтын 76 жилийн ойн баярыг тохиолдуулан соёл хүмүүжлийн төлөвлөгөөний дагуу амралтын өдрүүдээр цэргийн гэрээт алба хаагчид болон хугацаат цэргийн алба хаагчдын дунд “ойрын зайн гүйлт”, “гар дээр суниах” тэмцээнүүдийг зохион байгуулж явууллаа. Энэ үеэр ангийн захирагч хурандаа Х.Энхболд гар дээр суниалт, гүйлтийн тэмцээнүүдэд

оролцож цэргийн алба хаагчдад урам зориг өгч дайчидтайгаа нэг өдрийг хамтдаа өнгөрүүлээ. Мөн тус ангид сургалтад хамрагдаж байгаа Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн офицер ахлагч нар ангийнхаа танилцуулга, түүхэн замналыг харуулсан шторк, уулын тусгай хэрэгслийн үүрэг зориулалт, олсны зангилгааны төрлүүдийг танилцуулж төгсгөлд нь ахлах дэслэгч Ц.Цэсрэнжав байлдагч Ц.Батбаяр нар ая дууны мэндчилгээ дэвшүүлээ.

Хурандаа Г.НЯМДОРЖ

“НЭГ ӨРХ–НЭГ МОД”




Зэвсэгт хүчний 256 дугаар анги

“Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан ангийн албан тушаалын байрны хүүхдийн тоглоомын талбайд “Нэг өрх-Нэг мод” тарих аяныг зохион байгуулж 50 ширхэг мод тарьж, тоглоомын талбайн өнгө үзэмжийг сэргээлээ.

Хошууч Л.АМАРБАЯСГАЛАН

“ХАМТДАА ГЭРЭЭСЭЭ АНГЛИ ХЭЛ СУРЦГААЯ”



Зэвсэгт хүчний 303 дугаар анги

Тус ангийн Онгоц нисдэг тэрэгний сэлбэг хэрэгслийн нярав ахлах ахлагч П.Баярмагнайн санаачлагаар ахлагчийн зөвлөл, ахлагч нарын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “хамтдаа гэрээсээ англи хэл сурцгаая” цахим сургалтыг эхлүүлээд байна.

Тус сургалтад англи хэлийг сурах сонирхолтой ахлагч нараас гадна ангийн ажилтан алба хаагчид хамрагдах боломжтой аж. Тус хичээлийг ACL 1-10 дугаар номоос явуулж байгаа бөгөөд фэйсфүүк групп үүсгэн хамтдаа суралцаж байна.

Ахлах дэслэгч Г.БИЛГҮҮТЭЙ

ОРОН НУТАГТАА МОД ТАРИХ ӨДӨРЛӨГТ НЭГДЛЭЭ



Зэвсэгт хүчний 327 дугаар анги

Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын албан даалгавар, Хуурай замын цэргийн командлалын албан бичгийн бичгийн дагуу Дорнод аймаг дахь Хүний эрхийн Үндэсний комиссын референттэй хамтран ажиллах төлөвлөгөө байгууллаа. Хамтын ажиллагаагаар бие бүрэлдэхүүнийг гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчдад хүний эрхийн мэдлэг олгох, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэх юм.

Мөн Бүх нийтээр “Мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, “Гэрэл сэтгэмж” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай хамтран аймгийн төв зам дагуух нийтийн эзэмшлийн талбайд 300 гаруй шилмүүст модыг тарьж суулгалаа. Шилмүүст нь 15-28 метр хүртэл өндөр ургадаг мод аж.

Ахмад Д.ГАНБААТАР